

БАТЛАВ.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Т.АУБАКИР
2026 оны 05 сарын 15-ны өдөр



БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

С.АМАРСАЙХАН
2026 оны 05 сарын 15-ны өдөр



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна.Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 3.1.4-т “Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулна.” гэж, 3.1.5-д “Зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлдэг болно.” гэж тус тус зорилго дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.3.8-д “Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.” гэж, 2.1.3.9-д “Төрөөс үзүүлж байгаа нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.” гэж, 2.1.3.17-д “Улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэж тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн халамж, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эх нялхас, хөгжлийн бэрхшээлтэй хүн зэрэг нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна.” гэж заасан.

Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-д “Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар заасан зэрэг нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Нийгмийн халамжийн тухай хуулийг анх 1995 онд баталж, 1998, 2005, 2012 онд тус тус шинэчлэн найруулж байсан. Мөн нийгмийн халамжийн чиглэлийн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Ахмад настны тухай, Алдар цолтон ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулиуд тус тус хүчин төгөлдөр үйлчилж байна.

Нийгмийн халамжийн сангаас 2025 онд нийт зарцуулсан 2.4 их наяд төгрөгийн 72.2 хувийг буюу 1.7 их наяд төгрөгийг жирэмсэн эх, 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж, хүүхдийн мөнгө, Алдарт эхийн одонгийн мөнгө зэрэг эх, хүүхдэд чиглэсэн хөтөлбөрт, үлдсэн 27.8 хувь буюу 673.6 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг зэрэг зорилтот өрх, иргэнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжид зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь 2000 онд 1.1, 2019 онд 1.8, 2021 онд 4.5, 2023 онд 3.7, 2024 онд 3.2, 2025 онд 2.7 байна. Харин улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь нь 2000 онд 3.0, 2019 онд 5.8, 2021 онд 12.6, 2023 онд 9.9, 2024 онд 9.1, 2025 онд 10.7 байна. Харин хөгжиж буй орнуудын тухайд нийгмийн халамжийн зардал Дотоодын нийт бүтээгдэхүүний дунджаар 1.6¹ хувийг эзэлдэг бөгөөд үүнтэй харьцуулахад Монгол Улсын нийгмийн халамжид зарцуулж байгаа зардал харьцангуй өндөр юм.

Үндэсний статистикийн хорооны хийсэн судалгаагаар Монгол Улсын ядуурлын түвшин 1990 онд 36 хувь байсан бол 2022 онд 27.1 хувь болж, 913.7 мянган хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байна.² Монгол Улс 2025 оны байдлаар нийгмийн халамжийн хөтөлбөр, арга хэмжээнд жилд 2.4 их наяд гаруй төгрөгийг улсын төсвөөс зарцуулж байгаа боловч ядуурал дорвитой буураагүй байна.

Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд тулгамдаж буй гол асуудлын нэг нь халамжийн хамрах хүрээ хэт өргөн байна.

Нийгмийн халамжийн сангийн нийт зардлын 55 орчим хувь нь хүн амын хамгийн бага амьжиргаатай 40 хувьд, харин халамжийн зардлын 26 хувь нь хүн амын хамгийн амьжиргаа сайтай 40 хувьд зарцуулагдсан байна.³ Энэ нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд халамжид хамрагдах зорилтот бүлгийг сонгохдоо өрхийн

¹ “Монгол улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүд: Үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ” тайлан, 2015 он, Жунко Ониши, Чулууны Тунгалаг, Дэлхийн Банкны Групп

² Ядуурлын тооцооны арга зүйн өөрчлөлт, үр дүн-2022, ҮСХ, Дэлхийн банк, 2025 он

³ “Монгол улсын нийгмийн халамжийн систем: Зардлын хуваарилалт, халамж хүртэгчдийн төлөв байдал” 2019 он, Эрдэм партнерс ХХК

амьжиргааны түвшинд сууриллаагүй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх зэрэг хүн амын бүлэгт чиглэсэнтэй холбоотой.

Түүнчлэн Нийгмийн халамжийн нийт зардалд хөтөлбөрүүдийн зардлын эзлэх хувь ялгаатай байна. Тухайлбал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтийн зардлын 50 хувиас дээш хувь нь амьжиргааны түвшин хамгийн бага 40 хувьд хуваарилагдсан байна. Эхчүүдэд олгох тэтгэмжүүд, хүүхдийн мөнгө нь төдийлөн зорилтот бүлэгт чиглэгдээгүй буюу амьжиргааны түвшин хамгийн багатай 40 хувьд нийт зардлын 50 орчим хувь ногдож байна. Ахмад настанд олгох тэтгэмж, хөнгөлөлтийн амьжиргааны түвшин хамгийн бага 20 хувьд ногдож байгаа зардал нь амьжиргааны түвшин сайтай 20 хувьд ногдох зардлаас бага буюу 11 хувь байна.⁴

Эх, хүүхдийн чиглэлийн мөнгөн тэтгэмж, тусламж, насны хишиг зэргийг хасаж тооцоход 2025 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд давхардаагүй дүнгээр 370.4 мянган иргэн хамрагдаж байна.

Иймд нийгмийн халамжийн нийт зардал, хамрах хүрээг зохистой түвшинд байлгах, эдийн засгийн өсөлт, улс төрийн амлалтаас хамаарч халамжийн зардлыг өсгөхгүй байх шаардлагатай байна. Одоогийн зарцуулж байгаа нийгмийн халамжийн зардлыг бууруулах нь гол зорилго биш, харин санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлж, халамжийг нэн шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай байна.

Хэдийгээр нийгмийн халамжийн нийт зардал, хамрах хүрээ нь өргөн боловч 20 гаруй жилд ядуурал дорвитой буурахгүй, нөгөө талаас нийгмийн халамжийн зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцсэн халамж, үйлчилгээ шаардлагатай хэвээр байна.

Нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжийн зорилго нь нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хэсгийг хамгаалах, ядуурал болон эмзэг байдлыг бууруулахад чиглэдэг.

Одоогийн халамжийн бодлогод мөнгөн тэтгэмж давамгайлсан, халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болгох зарчмыг нэвтрүүлээгүй ба халамжийн ба хөдөлмөр эрхлэлтийн бодлого тус тусдаа хэрэгжиж байна. Иймд амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулахгүй олгодог эх, хүүхдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийг халамжаас ялгаж, зааглан гэр бүлийг дэмжихэд чиглэсэн бодлоготой уялдуулах нь зүйтэй юм.

Улс орнуудын нийгмийн халамжийн тогтолцоонд бэлэн мөнгө олгохоос илүүтэйгээр иргэдийг дэмжих, хөгжүүлэх, бие даан амьдрахад нь туслах үйлчилгээ давамгайлдаг бөгөөд манай улсын хувьд бэлэн мөнгөний хөтөлбөрүүд нийт халамжийн сангийн зардлын 90.0 гаруй хувийг эзэлж байна. Харин эрсдэлт нөхцөлд байгаа иргэдийг сургах, хөгжүүлэх, дэмжих, тэдний хэрэгцээнд нийцсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээнд 1.0 хүрэхгүй хувийг тус тус зарцуулж байна. Мөн олон нийтийн оролцоонд түшиглэн үйлчилгээг иргэн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэн хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцоо бүрдсэн ч санхүүжилт бага, хэрэгжилт хангалтгүй байдаг. Иймд нийгмийн ажлын мэргэжлийн

⁴ “Монгол улсын нийгмийн халамжийн систем:Зардлын хуваарилалт, халамж хүртэгчдийн төлөв байдал” 2019 он, Эрдэм партнерс ХХК

ажилтантай төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар иргэдийг дэмжих, хөгжүүлэх, бие даан амьдрахад нь туслах үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Мөн Нийгмийн халамжийн сангаас халамж, асрамжийн үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд үзүүлэх нь дараах хүндрэлийг үүсгэж байна. Сонгон шалгаруулалтын процесс явагдсаар үйлчилгээг жил бүрийн хамгийн эртдээ 4 эсвэл 5 сараас үйлчилгээг эхлүүлж байгаа нь тасралтгүй явуулах боломж алдагдаж, үзүүлж эхэлж байна. Мөн сонгон шалгаруулалт орж байгаа байгууллагууд доод үнийн санал өгөх боломжгүй Сангийн сайдтай хамтран баталсан үйлчилгээний жишиг тарифт үнийг мөрддөг, мөн шаардлага хангаж гэрээ хийсэн хэд хэдэн байгууллагаас иргэн өөрөө сонгон үйлчлүүлдэг зарчимтай тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй байна. Энэ нь бараа худалдан авалт биш харин үйлчилгээний стандартын шаардлага хангасан мэргэжлийн байгууллагатай нийгмийн үйлчилгээг гэрээлэх үйл ажиллагаа тул Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд зохицуулах шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулж тэдний амьжиргааг дэмжих, ажлын байртай болгох улмаар ядуурлаас аажмаар гарган бие даан амьдруулахад чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ дутмаг байна.

Иймд халамж хүртэгч өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх, амьдрах ухааны сургалт, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд шилжүүлэх хөтөлбөрт хамруулах, бие даан амьдрах дадлыг хэвшүүлэх зэргээр харилцан уялдаатай тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг бий болгож, төр, хувийн хэвшил, орон нутгийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Мөн архины хамааралтай, орон гэргүй болон асрамжаас гарсан, байгалийн гамшигт нэрвэгдсэн зэрэг төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай хүн амын онцлог бүлэгт чиглэсэн халамжийн үйлчилгээг сайжруулах, шинэ үйлчилгээ бий болгохыг олон улсын байгууллагууд зөвлөж байна.

Нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан хэрэгжиж байгаа эрүүл мэндийн чиглэлийн хэд хэдэн үйлчилгээнүүд байна. Тухайлбал, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд рашаан сувиллын хөнгөлөлт, протез, ортопед, тусгай хэрэгслийн зардлыг халамжийн сангаас олгож байна. Иймд үйлчилгээний хяналт, шалгалтыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой протез, ортопед, тусгай хэрэгсэл, сэргээн засах буюу рашаан сувиллын хөнгөлөлтийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалтай уялдуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааг эрүүл мэндийн байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалт хийх шаардлага тулгарч байна.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаагаа тодорхойлуулж халамжийн тэтгэвэр авч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмнэлэг хяналтын комиссын хурлаар

байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлуулж тэтгэмж, хөнгөлөлтөд хамрагдаж байгаа иргэдийн тоо жил бүр өсөж байна. Тухайлбал, байнгын асаргааны тэтгэмжид хамрагдаж байгаа иргэний тоо өмнөх оноос 2024 онд 11.5 хувиар, 2025 онд 6.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны гүйцэтгэлээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүний протез ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт гэх мэт мэргэжлийн эмч мэргэжилтний тодорхойлолтод үндэслэн үзүүлж байгаа үйлчилгээ 509.4 тэрбум төгрөг буюу зорилтот хэсэгт очиж байгаа халамжийн зардлын 75.6 хувийг эзэлж байна.

Иймээс халамж хүртэх иргэнийг зөв тодорхойлох тогтолцоог бүрдүүлэхгүйгээр тогтолцооны шинэчлэл хийгдэхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн тэтгэвэр, тэтгэмж, протез ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, асаргааны хувилбарт үйлчилгээ, хувийн туслах зэрэг үйлчилгээнд хамруулах, дэмжих, хөгжүүлэх цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх орон тооны болон орон тооны бус гишүүдтэй хамтарсан мэргэжлийн зөвлөлийг ажиллуулах тогтолцооны шинэчлэлийг бусад улс орны жишигт нийцүүлэн хийх нь зүйтэй байна.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, зуд зэрэг байгалийн гамшигт нэрвэгдэж малчид амьжиргааны эх үүсвэрээ алдаж, ядуу өрхийн тоонд орж байгааг анхаарч, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээг олон нийтийн оролцоонд түшиглэн үзүүлэх, энэ чиглэлд халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хүргэх бодлогын шинэчлэл хийх шаардлагатай байна.

Монгол Улс 2009 оноос орлогыг орлуулан тооцох аргачлалд суурилсан нийт өрхийн амьжиргааны түвшний мэдээллийн нэгдсэн сан, 2016 оноос нийгмийн халамжийн хөтөлбөрүүдэд хамрагдаж байгаа иргэдийн мэдээллийн сан (WAIS)-г⁵, 2020 оноос нийгмийн халамжийн нэгдсэн систем /ehalamj/-ийг нэвтрүүлж, уг цахим системээр дамжуулан халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Одоогийн өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг боловсронгуй болгох, зорилтот хэсгийг салбар дундын мэдээллийн сан, их өгөгдөлд суурилан үнэн зөв тодорхойлох төрийн бусад байгууллагатай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Халамжийн олон жижиг хөтөлбөр байгаа нь баримт бичиг бүрдүүлэх, мэдээллийн санд бүртгэх, олголт хийх зэргээр захиргааны хувьд шат дамжлагыг нэмэгдүүлж байгаа учраас хамрах хүрээ багатай, давтамж цөөн зарим хөтөлбөрүүдийг нэгтгэх, бүтцийг оновчтой болгох нь зүйтэй байна.

Цаашид эдгээр халамжийн мэдээллийн системийг уялдуулан нэгтгэх, төрийн бусад байгууллагатай мэдээлэл солилцох, түүнийг салбар дундын бодлого хөтөлбөрт ашиглах боломжийг нэмэгдүүлэхээс гадна зорилтот өрхийн амьжиргааг тодорхойлох

⁵ Welfare Administration Information System

аргачлалыг сайжруулах, Монгол орны нөхцөлд тохируулан өрхийн амьжиргааг бодитой үнэлдэг болох асуудал чухлаар тавигдаж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу хуулийн бүтэц уялдаа өөрчлөгдөж, хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Эх, хүүхдийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа, түүний төсөв, зарцуулалттай холбоотой асуудлыг халамжийн бодлогын хүрээнд бус гэр бүлийг дэмжих, хүн амын өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд тусгайлсан хуулиар зохицуулна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл нь хүн амын ядуу, эмзэг байдалд өртсөн зорилтот өрх, иргэний амьжиргааг дэмжих, нийгмийн халамжийн төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн арга хэмжээг хөдөлмөр эрхлүүлэхтэй уялдуулах замаар ядуурлаас гаргах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтуудыг тусгана. Үүнд:

-хуулийн зорилтыг тодорхойлж, нэр томъёог тодорхой болгож, нийгмийн халамжийн хамрах хүрээ, нийгмийн халамжийн арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмыг тодорхойлно;

-нийгмийн халамжийн тэтгэмжийн төрөл, тэтгэмж тогтоолгох, шийдвэрлэх хугацаа, түүнийг олгохтой холбогдох харилцааг зохицуулна;

-нийгмийн халамжийн дэмжлэг, үйлчилгээ түүний нөхцөл, шалгуур, хугацаатай холбоотой харилцааг тусгана. Зорилтот өрхийн хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг халамжийн хөтөлбөрүүдтэй уялдуулах, хүн капиталд хөрөнгө оруулах, үе дамжсан ядуурлаас сэргийлэх бодлого тусгана;

-нийгмийн халамжийн үйлчилгээ, түүний хамрах хүрээ, төрөл, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах бөгөөд зорилтот өрх, иргэнийг чадавхжуулах, хөгжүүлэх үйлчилгээг нэмэгдүүлж мэргэжлийн байгууллагын оролцоотой хэрэгжүүлэхээр тусгана;

-зорилтот өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэдийг халамжаас хараат бус байлгах, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх, зан хандлагыг өөрчлөх, нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, ажилтай орлоготой болгоход чиглэсэн үйлчилгээг нэвтрүүлнэ;

-гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн иргэдэд үзүүлэх нийгмийн хамгааллын хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлогыг тусгана;

-хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдлийн чадамж, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн тэтгэвэр, тэтгэмж, протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, асаргааны

хувилбарт үйлчилгээ, хувийн туслах зэрэг үйлчилгээнд хамруулах, дэмжих, хөгжүүлэх цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хамтарсан мэргэжлийн зөвлөлийг ажиллуулна;

-асрамжийн газраас гарсан хүүхэд, залуус, гэр оронгүй, архинд донтсон, хорихоос суллагдсан зэрэг нийгмийн зүгээс дэмжлэг зайлшгүй шаардлагатай иргэдийг бие даан амьдрахад дэмжих үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан тусгана;

-бэлэн мөнгөний бус нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг нэмэгдүүлж, мэргэжлийн төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх үйлчилгээг нэмэгдүүлнэ;

-нийгмийн халамжийн сан, түүний төрөл, орлогын эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалт, тайлан тэнцэл гаргах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна;

-нийгмийн халамжийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, тогтолцоо, нийгмийн ажилтан болон нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрх, үүрэгтэй холбогдох харилцааг тусгана;

-нийгмийн халамжийн салбарт мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, зорилтот бүлгийн өрх иргэнд кейс менежментийн үйлчилгээнд суурилан нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хэрэгцээнд суурилсан үйлчилгээ үзүүлэх, нийгмийн ажилтны мэргэжлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, нийгмийн ажилтан цаастай биш, өрх иргэн, олон нийттэй ажиллах, нийгмийн ажилтны үйл ажиллагааг ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ;

-нийгмийн халамжийн улсын байцаагчийн эрх зүйн зохицуулалтыг тусгаж, халамжийн хяналтыг сайжруулах зохицуулалтыг тусгана;

-нийгмийн халамжийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг тодорхойлно;

-мэдээллийн нэгдсэн сан, түүний бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, харилцан мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг тусгана. Амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг их өгөгдөлд суурилан шинэчилж, зорилтот өрхийн цахим мэдээллийн санг бүрдүүлнэ;

-нийгмийн халамжийн тэтгэмжээс суутгал хийх болон хууль тогтоомж зөрчигчид холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх талаарх зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн халамжийн өнөөгийн тогтолцооны хамрах хүрээ нь оновчтой, зорилтот бүлэгт чиглэсэн, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байж, халамжийн үйлчилгээ нь иргэдийн идэвх, сонголт, хэрэгцээнд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдах болно.

Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэмж, дэмжлэг, үйлчилгээний төрлүүдийг оновчтой тогтоон зарим хөнгөлөлт, тусламжийг нэгтгэн багцлах, иргэдийн амьжиргааг

сайжруулахад чиглэсэн шинэ үйлчилгээ бий болгох нь ядуурал буурахад эерэг нөлөө үзүүлэх болно.

Эрүүл мэндийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагад шилжүүлснээр санхүүжилтэд тавих хяналт сайжрах, давхардал хийдэл арилах, үйлчилгээ түргэн шуурхай, чанартай болох нөхцөл бүрдэнэ.

Халамжийн үйлчилгээ бүрэн цахимжсанаар нийгмийн ажилтны ажлын ачаалал буурч, зорилтот өрх, иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийх, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдэх юм.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж байгаа нийт зардлыг огцом бууруулахгүйгээр, одоогийн халамжийн төсвийн хүрээнд дахин хуваарилалт хийх зарчим баримтлах тул хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсгэхгүй юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.